

ЯАЖ ХРИСТЭД ИТГЭГЧ БОЛСНОО МЭДЭХ ВЭ?

ШИЛЖИН ДАМЖИХ УХАГДАХУУН

БИЛЛ БРАЙТ

Монгол Кампус Крусейд фор Крайст

*Улаанбаатар
2015*



Written by Bill Bright

“How you can be sure you are a Christian” ©

Campus Crusade for Christ Inc, 1971, 1981, 1991

“Яаж Христэд итгэгч болсноо мэдэх вэ?” ©

Монгол Кампус Крусейд фор Крайст 1998, 2015.

Библийн ишлэлүүдийг Ариун Библиэс авсан болно.

Ариун Библи © Ариун Бичээс Библийн Нийгэмлэг, 2004, 2013

ШИЛЖИН ДАМЖИХ УХАГДАХУУН ГЭЖ ЮУ ВЭ?

Бидний Эзэн Есүс хамгийн удаан хамт байж, авралын Сайн Мэдээг дэлгэрүүлэх ажлыг хамгийн их зааж сургасан арван нэгэн хүнд Эзэн дэлхий даяар явж үндэстнүүдийг дагалдуул хэмээн тушаав. Ингэхдээ Миний та нарт тушаасан бүхнийг сахин биелүүлэхийг тэдэнд зааж сурга гэжээ¹.

Хожим нь элч Паул Тимотод бас ийм үүрэг өгчээ. “Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга².”

Манай хамт олон гучин жилийн турш олон мянган оюутан, пасторуудад зөвлөгөө өгч, тэдэнтэй хамтран ажиллахдаа:

- Чуулганы маш олон гишүүн (Эзэнийг хүндэтгэж, түүний Үгийг итгэлтэй заадаг хүмүүс ч) авралын бат итгэлгүй
- Христэд итгэгч олон хүн цөхрөнгөө барсан амьдралтай
- Өөрсдийн итгэлээ бусадтай хэрхэн үр дүнтэй хуваалцахыг мэддэггүй болохыг олж мэдсэн юм.

1 Матай 28:18-20

2 2Тимот 2:2

Энэхүү үндсэн гурван хэрэгцээг хангаж, Христийн дагалдагчдыг бэлтгэхэд туслах үүднээс Кампус Крусейд фор Крайст байгууллага “Шилжин дамжих ухагдахуун” буюу “Яаж” цувралыг бэлтгэн Есүс болон Түүний дагалдагчдын зааж сургаж байсан гол гол үнэнийг та бүхэнтэй ярилцахаар зорьсон юм.

“Шилжин дамжих ухагдахуун” гэсэн нь нэгээс нөгөөд жинхэнэ утгыг нь гажуудуулахгүйгээр шилжин дамжиж байх ёстой гэсэн үзэл санааг хэлж байгаа юм. Ийнхүү хэвлэмэл ном, кино, дүрс бичлэг болон хуурцгаар дэлхийн олон орны хэл дээр хэвлэгдэж, дамжин явсаар дэлхий дээрх сая сая хүний амьдралыг Эзэний төлөө өөрчлөхөд туслах болтугай.

АГУУЛГА

1. Олон сая хүн итгэлгүй байдаг - **7**
 2. Христийг танин мэдэх агуу хүсэл - **9**
 3. Гурван талт гэрээ - **15**
 4. Бурханы цорын ганц арга зам - **38**
 5. Та итгэл төгс байж болно - **44**
- Бие даан суралцах хөтөч - **58**
- Бүлгээр ярилцах асуултууд - **62**

ОЛОН САЯ ХҮН ИТГЭЛГҮЙ БАЙДАГ

Цуглааны ахлагч, алдартай нэгэн бизнесмен миний ажлын өрөөнд өөдөөс минь хараад сууж байлаа. Хүмүүсийн үнэлэмжээр бол тэр гайхалтай амжилтанд хүрсэн нэгэн байв. Хэдийгээр тэр цуглааныхаа идэвхтэй удирдагчдын нэг боловч өөрийн мөнхийн хувь заяаны талаар итгэлгүй болох нь бидний ярианы явцад тодорхой болсон юм. Тэрээр өөрийнхөө авралыг баталгаатай болохыг баттай мэдэж авахыг ихэд хүсэж байлаа.

Нэгэн сайн мэдээ тараагчийн эхнэр “Сүүлийн гучин жилийн турш нөхөр бид хоёр олон мянган хүнийг Христтэй танилцууллаа. Харин би өөрөө аврагдсан гэдэгтээ хэзээ ч итгэлтэй байгаагүй. Одоо би үүнийг мэдэхийг маш их хүсэж байна. Надад таны туслалцаа хэрэгтэй байна...” гэж надад бас хэлж байсан удаа бий.

Христийг дөнгөж хүлээж авсан нэгэн оюутан Бурханаас залбиран гуйсныхаа дараа өндийснөө “Надад ямар ч өөрчлөлт мэдрэгдсэнгүй. Бурхан миний залбирлыг сонсоогүй гэж би бодож байна. Христ миний амьдралд орсон эсэхийг би яаж мэдэх

вэ?” гэж зовсон, эргэлзсэн байдалтай асууж билээ.

Магадгүй та ч гэсэн Эзэнтэй холбоотой эсэхдээ эргэлзэж байж болох юм.

Олон жилийн турш олон мянган оюутан, итгэгч нарт зөвлөгөө өгч байгаа туршлагаасаа харахад цуглаанд явдаг олон сая хүн Христийг өөрсдийн амьдралдаа урьсан, тэр ч бүү хэл ихэнх хүмүүс дахин дахин урьсан байдаг боловч өөрсдийн авралын талаар багтай итгэлгүй байдгийг би олж мэдсэн. Үнэн хэрэгтээ судалгаанаас үзэхэд, АНУ-д цуглааны гишүүдийн тавин хувь нь өөрсдийнх нь амьдралд Христ оршин байгаа гэдэгт итгэлгүй байдаг юм. Эдгээр хүмүүс бол угтаа их сайн хүмүүс. Тэд ихэнхдээ өөрсдийн цуглаанд олон жилийн турш сайн үйлчилсэн хүмүүс байдаг. Харин Христ оршин байгаа гэдэгт итгэлгүй байдаг бөгөөд хэрвээ тэд өнөөдөр нас барлаа гэж бодоход Их Эзэнтэй хамт байхаар тэнгэрийн хаант улсад очно гэсэн итгэл тэдэнд байхгүй.

Яагаад ийм сэтгэл шимшрэм тодорхойгүй байдал сүсэг бишрэлтэй хүмүүсийн дунд байсаар байна вэ? Тэдний энэ үл итгэх байдал нь буруу мэдээллийн улмаас, эсвэл Бурхан гэж хэн бэ? гэдэг талаар мэдлэг хомс байгаагаас болж байна гэж би үздэг. Бурхан гэж хэн бэ гэсэн ойлголтонд Христ бол

хүний дүртэй Бурхан, бидний Их Эзэн цовдлогдож үхээд дахин амилсан, Есүс Христийг Аврагч Их Эзэнээ болгон хүлээж авахад юу хэрэгтэйг ойлгох зэрэг нь багтана.

Маш чухал энэ асуултыг би танаас асууя. Харин та энэ талаар юу гэж бодож байна? Хэрвээ та өнөөдөр нас барвал ямар ч эргэлзээгүйгээр тэнгэрийн хаант улсад очно гэсэн бат итгэл танд байна уу?

Дараагийн хуудаснуудад би та нартай агуу их найдварын тухай нэгэн мэдээг хуваалцахыг хүсэж байна. Дэлхий дахин энэ мэдээний өлсгөлөнд нэрвэгджээ. Энэ бол цуглааны хувьд хамгийн чухал мэдээ гэж би бодож байна.

ХРИСТИЙГ ТАНИН МЭДЭХ АГУУ ХҮСЭЛ

Христийг таньж мэдэх гэсэн агуу их хүсэл бүх хүн төрөлхтөнд байдгийг би олж мэдсэн билээ. Би зөвхөн хэдэн жишээ татъя.

Нэгэн найз маань намайг өөрийнхөө ахтай уулзахыг хүссэн юм. Ах нь Христэд итгэдэггүй учир тэр түүний төлөө санаа зовж байв. Тэр хүн манай

орны улс төр, эдийн засгийн томоохон удирдагчдын нэг байлаа.

Бид уулзах цагаа товлон. Би өөрийгөө танилцуулсны дараа дэлхий ертөнцийн өнөөгийн байдлын талаар, ёс суртахуун, оюун санааны сэргэлт хэрэгтэй байгаа талаар товчхон ярилцсан юм. Тэр ярьсан бүхнийг минь зөвшөөрч байлаа. Бурхан түүнийг чухал албанд томилсныг нь би онцлон дурдаад, дэлхийг сайн сайхан болгож өөрчлөх үйлсэд түүнийг их хувь нэмэр оруулж чадна гэж хэллээ. Гэхдээ эхлээд өөрийг нь өөрчлөхийг Бурханд зөвшөөрөх хэрэгтэй гэж түүнд хэлэв.

Би түүнд *Танд зориулсан гайхамшигт төлөвлөгөө* номыг өгөөд надтай хамт уншихыг хүслээ. Энэ бяцхан номыг уншиж дууссаны дараа нэрт улс төрч маань Христийг хүлээж авахыг хүсэж байгаагаа даруухнаар илэрхийлсэн юм. Тэгээд бид хамтдаа Эзэнээс гуйн залбирлаа. Залбирч дууссаны дараа тэр “Би үнэхээр үүнийг хүссэн гэдгээ танд хэлэх гэсэн юм. Юу хийх ёстойг минь хэлж өгөөч” гэлээ.

Солонгост Кампус Крусейд фор Крайст байгууллагын сургалтанд хамрагдаж байсан арван мянга гаруй оюутан, олон итгэгч, пастор дөчин хоёр мянга гаруй хүнд яаж Христэд итгэгч болох тухай

ярьж өгчээ. Арван зургаан мянга гаруй нь тэдэнтэй хамт Бурханаас залбирч, Христийг хүлээн авчээ. Үүнээс гадна гурван мянга найман зуун хүн Ариун Сүнсээр дүүрэн байх хүсэлтэйгээ илэрхийлжээ.

Гайтид ийм сургалтын үеэр таван зуун пастор, цуглааны ахлагч нийлж *Танд зориулсан гайхамшигт төлөвлөгөө* номыг ашиглан Сайн Мэдээг тунхаглаж нэг өдөрт мянга гаруй хүн Христийг хүлээн авчээ. Сүүлийн хэдэн жил Ванет бид хоёр ОХУ-д хэд хэдэн удаа очлоо. Бидний үзэж сонссон зүйл гайхамшиг байлаа. Орос хүмүүсийн оюун санааны өлсгөлөн, Сайн Мэдээг хүлээж авч байсан нээлттэй байдал нь бидний төсөөлж байснаас хавьгүй илүү байсан юм. Христэд итгэгч ахлагч нар боломжит бүх газраар явж Сайн Мэдээг тунхаглан маш олон хүн үүнд нь хариулж байлаа.

ОХУ-д Олон улсын эмэгтэйчүүдийн баярын өдрөөр анх удаа зохиогдсон нэгэн чуулга уулзалтын үеэр Ванет үг хэлсэн юм. Түүний яриаг сонсохоор гурван зуу гаруй эмэгтэй зуун жилийн өмнө баригдсан хуучин протестант сүмд цугласан байв. Тэр Бичээсээс нэг цаг ярьж, үргэлжлүүлэн хоёр цаг хагасын турш асуулт хариултын цаг гаргасан нь тэнд оюун санааны өлсгөлөн хичнээн их байгааг тодорхой харах боломж байлаа.

Өнгөрсөн хэдэн сард олон мянган хүн “Есүс” киног үзсэний дүнд Христийг хүлээж авлаа. Одоогийн байдлаар зургаан зуун сая гаруй хүн энэ киног үзэж, олон сая хүн Христийг Аврагч, Их Эзэнээ болгон дагах хүслээ илэрхийлсэн байна. Сибирыт Сайн мэдээг хүлээж авахад хүмүүс нээлттэй байгааг олж мэдсэн Христэд итгэгчид тэсгим өвлийн хүйтэнд ч “Есүс” киног бүтэн өдрийн турш үзүүлж байжээ. Энэ бол АНУ-д ч сонсогдоогүй үр дүн юм. Хүн орох зайгүй өрөөнд хоёр цаг тутамд “Есүс” киног гаргаж байв. Шөнийн 12, үүрийн 2, 4 цагт ч киног үзүүлж байлаа. Дал гаруй жил Бурханаар өлсөж цангасан оросууд бидний гайхамшигт Аврагчийн тухай мэдэж авахаар Сибирийн хүйтэн шөнийг ч тэсвэрлэн давж байсан юм.

Румынд нэгэн хүн Сайн мэдээг хүмүүс хүлээж авахад хэрхэн бэлэн байгааг “Манай хүмүүс өлсөж байна. Тэд маш их цангасан байна. Оюутан, залуучууд, ер хэнтэй ч уулзаад Христэд итгэгчдийн номыг өгөхөд, тэд маш их баярлаж байна!” гэж ярьсан юм. Румыны нэгэн пастор “Биднийг цуглах бүрт тав, зургаан мянган хүн ирдэг, харин бид 1500 хүний суудалтай байртай. Ихэнх хүмүүс бүтэн сайны өглөө гурван цаг, бүтэн сайны орой хоёр

цаг, тав дахь өдрийн орой хоёр цаг зогсоогоороо цуглаанд оролцдог. Гудамж, хонгил ч пиг хүнтэй байдаг. Бороо, цас орж байсан ч, зуны халуунд ч тэд байж л байдаг. Цуглаандаа ирэх бүртээ гудамжны өнцөг булан бүрээс энэ газар руу ирж яваа хүмүүсийг хараад миний зүрх дулаацах шиг болдог. Би зөвхөн Бурханыг магтдаг!” гэж ярьсан юм.

Баруун европоор дамжин аялдаг Зүүн европынхонд Библи тараадаг Баруун европод амьдардаг миссионерүүд Зүүн европынхны дунд Бурханы Үгийг сонсох хүсэл хичнээн их байдаг тухай бас ярьж байсан юм. Эдгээр миссионерүүд Болгар, Польш, Чех, Орос, Румыны усан онгоц, автобус, галт тэргэнд Христэд итгэгчдэд зориулсан ном тарааж байхдаа оюун санааныхаа гүн гүнзгий хэрэгцээг хангахын тулд тэд Библи олж авахаар тэсэн ядан хүлээж байдгийг олж мэдсэн байна.

Түүгээр ч барахгүй Куба, Этиоп, Хятадын далайчид ч оюун санааны цангаагаа тайлахыг хүсэж байдаг. Хятадын усан онгоцон дээр гарах зөвшөөрөл авсан нэгэн миссионер олон далайчин Библи олж авахыг тэсэн ядан хүлээж байсан тухай ярьжээ. Нэг усан онгоцон дээр Библи, Шинэ Гэрээгээр дүүрэн байсан түүний богц хэдхэн секундын дотор хоосорчээ.